



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2018 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 176

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Хөгжлийн зам” үндэсний хөтөлбөр, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2014 оны 64, “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоол, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 35/32 дугаар зөвлөмж, “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор тус чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, холбогдох тооцоо, судалгааг боловсруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн
ахлагч

-Зам, тээврийн хөгжлийн сайд Я.Содбаатар

Гишүүд:

-Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг;

-Барилга, хот байгуулалтын дэд сайд
Ш.Лхамсүрэн;

-Зам, тээврийн хөгжлийн дэд сайд
Л.Халтар;

-Ерөнхий сайдын орон тооны бус зөвлөх
Ж.Бат-Эрдэнэ;

-Газар зохион байгуулалт, геодези, зураг
зүйн газрын дарга Ц.Ганхүү;

-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын дарга Ц.Ням-Осор;

-Өмнөговь аймгийн Засаг дарга
Н.Наранбаатар;

-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны
Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн
удирдлагын газрын дарга Г.Нямдаваа;

-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Б.Дэлгэржаргал;

-Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Батболд;

-Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирал Б.Батбаяр;

-“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг;

-“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Цэнгэл.

Нарийн бичгийн
дарга

-“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төслийн хэлтсийн дарга Б.Батцэнгэл.

2. Техник, эдийн засгийн үндэслэл, холбогдох тооцоо, судалгааг 2018 онд багтаан боловсруулж, Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ